



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Баярцогт -Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын гишүүн
Б.Чойжилсүрэн -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Баярцэцэг -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Н.Энхтуяа -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга

Т.Баттулга -Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга

Ш.Жолбарс -Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга

Ц.Ганболд -Хууль зүйн яамны Дотоод хэргийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга

Т.Зул

-Хууль зүйн яамны Дотоод хэргийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах
хэлтсийн мэргэжилтэн

Ж.Галбадрах


-Монголын хувийн хэвшлийн бага, дунд
холбооны тэргүүн

Э.Түвшинжаргал
Г.Нямдэлгэр
Б.Батчимэг

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх
-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх
-Хууль зүйн байнгын хорооны референт

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Ж.Батзандан/-д зөвшөөрсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ